

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

“Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн тухай”

2025 оны 06 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Нэг. Хяналт- шинжилгээ хийх үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалыг тус тус үндэслэв.

Хоёр. Хяналт- шинжилгээний зорилго

Засаг даргын Тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн төлөвлөгөөт ажил, дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Гурав. Хяналт- шинжилгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын холбогдох заалтыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд дараах хяналт-шинжилгээний аргачлалыг хэрэглэв.

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} * 100$$

“Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын 2.4, 2.5 дах заалтын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах аргачлалын дагуу үнэлэв.

➤ **“Бүрэн хангалттай”** төлөвлөгөөний хэрэгжилт 85 түүнээс дээш хувь (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн);

➤ **“Хангалттай”** төлөвлөгөөний хэрэгжилт 70-85 хүртэл хувь бол (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах);

➤ **“Хангалтгүй”** төлөвлөгөөний хэрэгжилт 70 хүртэл хувь бол (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон);

Дөрөв. Хяналт- шинжилгээний үр дүн

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцсан хэлтэс, албан тушаалтнаас

цаасан суурьтайгаар хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хяналт-шинжилгээ хийж ажилласан болно.

Засаг даргын Тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр 4 хэсэг 9 зорилго 236 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн биелэлтийг тайлагнан ажилласан байна.

Төлөвлөсөн 236 ажил, арга хэмжээг тайлагнасан байдалд аргачлалын дагуу хяналт-шинжилгээ хийхэд:

“Бүрэн хангалттай” төлөвлөгөөний хэрэгжилт 85-аас дээш хувьтай-84

“Хангалттай” төлөвлөгөөний хэрэгжилт 70-85 хүртэл хувьтай -27

“Хангалтгүй” төлөвлөгөөний хэрэгжилт 70 хүртэл хувьтай - 89

Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй – 36 ажил, арга хэмжээ байна.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнасан 236 ажил, арга хэмжээг журамд нийцүүлэн хяналт-шинжилгээ хийхэд хэрэгжилтийн дундаж 69,3 хувьтай байна.

№	Агуулга	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь				Хувь
				85-100	70-84	0-69	ХБ	
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	27	91	32	9	42	8	70,1
2	Засаг даргын Тамгын газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд	1	21	7	4	8	2	71
3	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	5	71	28	6	24	13	70,5
4	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ	15	53	17	8	15	13	70

Тав. Хяналт-шинжилгээний дүгнэлт

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 хэсэг, 9 зорилго, 236 ажил, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд:

Тайлагнасан 236 ажил, арга хэмжээг холбогдох журамд нийцүүлэн үнэлэхэд үнэлгээний дундаж 69,3 хувийн гүйцэтгэлтэй буюу Хангалтгүй гэж дүгнэгдэж байна.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ 70,1%, Засаг даргын Тамгын газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх ажил,

арга хэмжээ 71%, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ 70,5%, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ 70%-ийн хэрэгжилттэй байна.

Нийт 236 ажил, арга хэмжээнээс оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн 83 ажил, арга хэмжээ, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах 27 ажил, арга хэмжээ, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон 89 ажил, арга хэмжээ, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 36 ажил арга хэмжээ байна.

Үр дүн гараагүй буюу "0"-ийн гүйцэтгэлтэй 2 ажил, арга хэмжээ байна.

1.7.2.Эрүүл мэндийн төвд хүчилтөрөгчийн үйлдвэр барих ажлыг зохион байгуулах	580.0 Нийслэлийн төсөв	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	0	100,0	2025 оны 04 дүгээр сард Эрүүл мэндийн төвд хүчилтөрөгчийн үйлдвэр барих ажлын тендэр зарлагдаж, сонгон шалгаруулалтаар "Ай Мэд Техноложист" ХХК компани шалгарч, нийслэлийн Өмчийн харилцааны газарт гэрээ байгуулах шатандаа ажиллаж байна. Гэрээ хийгдвэл хүчилтөрөгчийн үйлдвэр барих ажлыг 2025 оны 07 дугаар сард багтаан дуусгахаар бэлтгэл хангаж байна.	50	0
1.2.5.Дүүргийн Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангах, үр дүнг тооцож тайлагнах.	8.0 Дүүргийн төсөв	Хэрэгжилт, хувь	91,0	100,0	Дүүргийн Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг боловсруулж байна.	30	0

Зургаа. Цаашид анхаарах асуудал

1. Төлөвлөгөөний хэрэгжээгүй ажил, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодорхой тусгах

2. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн хэрэгжих боломжит хугацааг тооцож, нарийвчлан гаргах

3. Төлөвлөгөөний биелэлтийг хэмжих нэгж, шалгуур үзүүлэлтийг хүрээнд тайлагнах

4. Тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, нотлох баримтыг хавсаргаж, тодорхой гаргах

Долоо. Зөвлөмж

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдад Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг танилцуулж, хэрэгжүүлэн ажиллах

2. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа үр дүнг тооцсон, тоо баримтыг нэгтгэсэн арга хэмжээг хэмжих, үнэлэх үндэслэлтэй хоёр мянган тэмдэгтэд багтаан хэрэгжилтийн явцыг товч тодорхой, нотлох баримтыг хавсаргасан байх

3. Нэгжийн дарга нар гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилтэд анхаарч, төлөвлөгөөт ажлуудаа тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хариуцсан албан хаагчийг үүрэгжүүлж, хяналт тавьж ажилладаг байх

ХЯНАСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА



С.ТУУЛМАА

БОЛОВСРУУЛСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



О.ЯНЖИНЛХАМ